



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 148.

Улаанбаатар хот

Г

Т

Судалгааны ажил зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.14, тус газрын дүрмийн 2.3, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн аялал жуулчлалын таталцлын бүсэд аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөцийг тогтоох судалгааны ажлыг зохион байгуулахыг хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/, судалгаа хийх ажилд тус газрын ажилтнуудыг татан оролцуулахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/ нарт тус тус даалгасугай.
2. Судалгааны ажлын удирдамжийг нэгдүгээр, судалгаанд шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Судалгаа хийхэд шаардагдах төсөв 1.458.500 /нэг сая дөрвөн зуун тавин найман мянга таван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА





Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20... оны ... сарын ... өдрийн  
*Аялал*, тоот тушаалын нэгдүгээр хавсралт

УОА0453

## ХОТ ОРЧИМД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ ТОГТООХ СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

### Зорилго:

Улаанбаатар хотын аялал жуулчлалын таталцлын бүсэд хамаарах 670 км<sup>2</sup> талбайтай Багануур, Багахангай дүүргүүдийн бичил бүсэд аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөцийг судалж, маршрут тогтооно.

### Хугацаа:

2014 оны 9-р сарын 15-наас 19 –ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

### Хамрах хүрээ:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд 4 хоногт багтаан хариуцсан ажлын чиглэлээр судалгаануудыг хийж гүйцэтгэнэ.

### Хүрэх үр дүн:

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэнээр дараах үр дүнд хүрнэ.

- Судалгаанд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломж бий болно.
- Аялал жуучлалын гол бүс болгон хөгжүүлэх, томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болно
- Хот орчимд дотоодын аялагчдын сонирхлыг татах үзмэрүүдийг нээн илрүүлнэ.
- Аяллын шинэ чиглэлүүдийг тогтооно.
- Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой болно.

**Судалгааны чиглэл:**

Дараах чиглэлд судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

№	Судалгааны чиглэл	Хариуцах эзэн
1	Багануурын бичил бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөцийг тогтоох	Б.Ербахыт
2	Олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын цогцолбор барих, боломжтой газруудыг сонгох	Г.Гансувд
3	Үзмэрүүдэд үнэлгээ өгөх, он сайт аудит хийх	М.Баасандорж
4	Үзмэрүүдийн байршил, газарзүйн солбилцлыг тодорхойлох	Б.Оюунзул
5	Аялал жуулчлалын рекреацийн үнэлгээ хийх	Б.Жаргалан
6	Явган, морин аяллын чиглэл тогтоох /гурван чиглэлд гурван баг болж явах/	Б.Халиун
7	Орон нутгийн иргэд, захиргааны байгууллагуудтай уулзах, хамтран ажиллах байгууллагуудтай харилцаа тогтоох	Д.Ганболд
8	Жуулчдыг байршуулах хэрэгсэл, хүчин чадлыг судлах, үйлчилгээний стандартыг хангах талаар зөвлөгөө өгөх	С.Түүл
9	Борнуурын бүс орчмын үзмэрүүдийн зургийн сан үүсгэх, маркетингийн сурталчилгаанд ашиглах, тайлбар мэдээлэл бэлдэх Мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байрлуулах, хэвлэл мэдээллээр сурталчлах	Д.Жаргалсайхан



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20.11.оны ... сарын ... өдрийн  
Аи тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ХОТ ОРЧИМД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ ТОГТООХ  
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Зам хоногийн мөнгө	9	35.500*4хоног*9хүн	958.500
2	Унаа /турээсийн зардал/	2	250.000	500.000
	Дүн	-	-	1.458.500

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ:

П.АРИУНАА

Огноо: .....

БОЛОВСРУУЛСАН:

ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

Э.МӨНХЗУЛ

Огноо: .....